

МОНГОЛЫН ХУТАГТ ХУВИЛГААДЫН ТАЛААРХ ЗАРИМ ТООН БА ЧАНАРЫН СУДАЛГААНЫ ХАРЬЦУУЛАЛТ

М.Гантуяа (Ph.D, профессор)
Философи, шашин судлалын тэнхим
ШУС, МУИС
Дарханхүү (докторант)
ӨМӨЗО, БНХАУ

Түлхүүр үгс : Монголын хутагт хувилгаадын талаархи тоон мэдээлэл, Монголын хутагт хувилгаадын талаархи чанарын судалгаа, тоон ба чанарын судалгааны харьцуулалт

Товч утга: Монголд хутагт хувилгаадыг анх хэдий үеэс тодруулсан, тэр нь ямар учир шалтгаантай байсан, хорьдугаар зууны гучаад он хүртэл хичнээн хутагт хувилгаад тодорсон, түүний цаана монголчуудын сэтгэл санааны ямар хүсэл сонирхол нуугдаж байсан, энэ талаар ямар ямар судалгаа байдгийг болон сүүлийн үед тодорсон хутагт хувилгаадын талаархи тоон ба чанарын судалгаа хийхийг бид зорьсон юм. Энэхүү илтгэлдээ дараахь хоёр асуудлыг хөндөв.

Нэгд, Эртний болон өнөө цагийн Монголын хутагт хувилгаадын талаархи Орос болон Хятад сурвалжийн мэдээллийг харьцуулах,

Хоёрт, Монголд хутагт хувилгаад тодруулж ирсэн үйл явцыг монгол хүний сэтгэлзүйн онцлогт харгалдуулж авч үзнэ.

* * * * *

Сүүлийн үеийн Орос болон Монголын судлаачдаас XIX зууны сүүл үед Монголд зорчиж байсан Оросын монгол судлаач А.М.Позднеевын судалгаанаас эшлэл авах нь элбэг байна. Тэгвэл бид уг судалгааг өнөө үеийн Хятад дахь Манжийн үеийн талаархи зарим мэдээлэлтэй харьцуулахыг оролдлоо.

Монголд хутагт хувилгаад тодруулж ирсэн түүхэн үйл явцын цаана монголчуудын сэтгэл санааны зорилго, хутагт хувилгаадыг шүтэж ирсэн монгол хүмүүний сэтгэлзүйн онцлог юу болох, орчин үед хутагт хувилгаадыг олноор тодруулж байгаагийн нийгэм-сэтгэлзүйн үндэс юу болох зэрэг асуудлыг энэхүү илтгэлдээ мөн хөндөж ярихыг хичээлээ. Эцэст нь хутагт хувилгаадыг тодруулах тоон болон чанарын үзүүлтийн харилцан хамаарлыг тодруулахыг гол зорилгоо болгосон юм.

Эхлээд нэрний тухайд товч тайлбар хэлье. Үүнд:

1. “Монголын хутагт хувилгаадын талаархи тоон мэдээлэл” гэдгээр Монголд эрт үеэс өнөөг хүртэл хичнээн хутагт хувилгаад тодорсон тухай мэдээллүүдийг танилцуулах юм.

2. “Монголын хутагт хувилгаадын талаархи чанарын судалгаа” гэдэг нь Монгол дахь хутагт хувилгаадын тоонд харгалзах тухайн үеийн төр, нийгмийн хандлага, монголчуудын хутагт хувилгаадыг шүтэж ирсэн нийгмийн сэтгэлзүйн онцлогийг авч үзэх юм.

3. Тоон ба чанарын судалгааг харьцуулна гэдгээр тоо өсөхийн хэрээр, эсвэл тоо багасахын хэрээр бурханы шашны дэлгэрэлт болон нийгмийн харилцаанд ямар өөрчлөлт хувирал явагдаж байгаа талаар санал бодлоо хуваалцах юм.

Сүүлийн үеийн Орос болон Монголын судлаачдаас XIX зууны сүүл үед Монголд зорчиж байсан Оросын монгол судлаач А.М.Позднеевын судалгаанд тулгуурлан Монголд тодорсон хутагт хувилгаадын тоог тодорхойлох нь элбэг болжээ. Тэгвэл бид энэхүү илтгэлдээ уг судалгааг өнөө үеийн Хятад дахь Манжийн үеийн талаархи зарим мэдээлэлтэй харьцуулахыг оролдлоо.

А.М.Позднеевын бичсэн “Монгол дахь Буддын сүм хийд, Буддын шашны ахуй амьдралын тойм” (Очерки быта Буддийских монастырей и Буддийского духовенства в Монголии) хэмээх номноос бид Монголын хутагт хувилгаадын тооны талаар дараахь мэдээллийг авч байна. Үүнд.

1. Монголын Буддын судлал, ялангуяа хутагт хувилгаадын талаархи мэдээллийг XIX зууны Оросын эрдэмтэд ихэд сонирхож байжээ.
2. Монголын нийслэл Өргөө-д ажиллаж байсан Шанзодвын яамнаас зөвхөн Ар Монголын хутагт хувилгаадын жагсаалтыг гаргадаг байсан байна.
3. Оросын эрдэмтдээс В.П.Васильев Бээжинд арав гаруй жил сууж Ар, Өвөр Монголын хутагт хувилгаадын 144 нэрсийн жагсаалтыг гаргасан нь Орос болон Европчуудаас гаргасан анхны жагсаалт юм байна.
4. А.М.Позднеев энэхүү жагсаалтыг өөрийн номондоо оруулснаас гадна Шанзодвын яамны жагсаалтаас халхын 44 хутагт хувилгаадын нэрсийг нэмж, халхад нийт 118 хутагт хувилгаан байна гэсэн тоон мэдээллийг өгчээ.
5. Оросын судлаачдын мэдээлснээр дээрхи жагсаалт аль аль нь бүрэн гүйцэд биш бөгөөд Өвөр Монголд Ар Монголынхоос илүү олон хутагт хувилгаад байжээ.
6. А.М.Позднеевын мэдээлснээр Өвөр Монголд Донхор Манзушрийн гэгээн буюу Донхор хутагт анх тодорсон боловч түүний дараа төрлүүд нь Ар Монголд суурьшсан, харин Ар Монголын анхны хутагт нь Богд Жавзандамба хутагт мөн бөгөөд түүнээс өмнө Өвөр Монголд Донхор хутагтыг нэгэнт тодруулсан байсан гэжээ.
7. Монголчууд хутагт хувилгаадын сүм хийдэд маш их өглөг хандив өргөдөг байсан тул хутагтын сүм хийд бусад сүм хийдээсээ илүү чинээлэг байсан байна.
8. Жирийн сүсэгтэн олон хутагт хувилгаадыг жирийн хүн бус, ид шид үзүүлэгч гэдэг талаас нь илүү домогчлон ярьж биширдэг байжээ.

Одоо А.М.Позднеевын өгсөн дээрхи мэдээллийг өнөө үеийн Хятад дахь Манжийн үеийн талаархи зарим тоон мэдээлэлтэй харьцуулахыг оролдоё.

Ли Пан юан¹ данс эмхтгэлээс харахад, Чин гүрний сүүлийн үе буюу XX зуун гарахаас өмнөхөн Өвөр монголд 1200 гаруй сүм, Ар халхад 700 гаруй сүм хийдтэй байсан ба тэдгээрт сууж байсан Монголын хутагт хувилгаадын тоог бүртгэвэл 243 хүрч, түүний дотор Өвөр монгол хутагт хувилгаадын тоо нь 157² байсан гэж тэмдэглэжээ. Үүнээс Өвөр Монголын 144 хутагт хувилгаад, Ар Монголын 44 хутагт хувилгаадын нэрсийг А.М.Позднеев жагсаасан байна. Ямартай ч Өвөр Монголд илүү олон хутагт хувилгаад байжээ.

Бас нэгэн анхаарал татсан зүйл бол, Өвөр Монгол сурвалж бичгүүдэд Нэйж тойныг хамгийн анхны хутагт хэмээн өргөмжилдөг бол А.М.Позднеевын тэмдэглэлд: “...Халхад Жавзандамба хутагт тодрохоос өмнө Өвөр Монголоос Донхор Манзушри гэгээн ирж сүм

¹ 理藩院 (lǐ pān yuàn)

² “Жирмийн сүм гийд” хуудас 6.

хийд байгуулах тал дээр ч, бурхан шашин номлох лам хуврагуудыг олшруулах тал дээр ч идэвхтэй анхаарал тавьж байсан нь тодорхой. Түүнийг нас барахад шинээр төрсөн хувилгааныг нь Төвдөөс Халхад авчирсан ба тэр үеэс Донхор хутагтын хувилгаанууд өнөөг хүртэл Монголд аж төрж байна...” хэмээснээс үзэхүл Позднеевын ажигласнаар монголчууд бурхан шашиныг Ар халхад анх авчирсан хүн бол Манзушри гэгээн хэмээн үздэг байсан ажээ. Энд тэмдэглэн хэлэхэд хоёрдугаар Богд Жавзандамба хутагтын номын багш “Донхор хутагт” хэмээн монголчуудын дунд алдаршсан хүн бол Позднеевын номонд бичсэн Донхор хутагт биш юм. Үүнийг тодруулбал, Цагаан номын хаан, Манзушри хутагт, Майдар хутагт, Ёнзон хутагт гэх мэт нэрээр алдаршсан Донхор Даваажанцан Манзушри хутагт бол шинжлэх ухааны доктор Л.Тэрбиш багшийн өгүүлснээр 1476-1556 онд амьдарч байсан. Харин 1725-1757 оны хооронд амьдарч байсан Халхын хоёрдугаар Богдын ёнзин багш байсан Хөхнуурын Манзуширийн гэгээн Донхор хутагт Агваанжамбалданзангийн талаар Монголын түүх бичигт: Анхдугаар дүрийн Донхор хутагт 1695-1750 оны хооронд амьдарч байсан гэжээ.

Донхор хутагт хэмээн алдаршсан гурван хутагт байгааг Өвөр Монголын шашны толь бичигт дурджээ. Тухайлбал,

Төвдөд анх тодорсон Донхор хутагтын 12 дүр:

Даваажалсан дүйнхор хутагт	1476-1556	Төвдийн Камба орон
Ёнданжамц дүйнхор хутагт	1557-1587	Төвдийн дунд Камба орон
Жалбижамц дүйнхор хутагт	1588-1639	Төвдийн баруун камба орон
Дэжиджамц дүйнхор хутагт	1621-1683	
Содномжамц дүйнхор хутагт	1684-1753	Хөхнуур
Жамьян-Данжинжамц	1774-1798	Хөхнуур
Галсан-Жамьянжамц	1799-1811	Хөхнуур
Түвдэн-Жигмэдгалсан	1813-1819	
Түвдэн-Жигмэджамц	1820-1883	
Гажүджамц	? -1909	
Цүлтэмжамц	1910-1918	Цахар нутаг
Лувсанжанчүв Данжинжамц	1920-1983	Хөхнуур

Бадгар сүмийн Донхор хутагт 8 дүр:

Лувсанжамц	1659-1763	Хөх хот
Ишдорж	1764-1836	Хөх хот
Ишилувсан-Данжинжамц	1838-1854	Халхын Түшээтхан аймаг
Галсантүвдэн	1855-1886	Улаанцавын чуулган
Агванданжин-Принлайнамжил	1887-1918	Улаанцавын чуулган
Түвдэнгалсан	1919-1943	Улаанцавын чуулган
Лувсанпэринлай-Дамбийжалсан	1944-1955	Улаанцавын чуулган
Галсантүвдэн-Чойживанчагийн хувилгаан Улаан гэгээн буюу Лувсанжамъянсэнгэ (Алмас)	1992-	Дархан Муумянган хушуу

Халхын Манзушри Донхор хутагтын 6 дүр:

Аймаг савыг баригч Ачит Номун хан Донхор хутагт Агваанжамбалданзан	1695- 1750
II дүр Манзушир хутагт Лувсантүвдэнванчүг	1754- 1816
III дүр Манзушир хутагт Лувсанжигмэдчүлтэм	1816- 1842
IV дүр Манзушир хутагт Дашдондов	1843- 1850
V дүр Манзушир хутагт Ринчиндорж	1850- 1871
VI дүр Манзушир хутагт Цэрэндорж	1872-1937

Монголын анхны хутагтуудын он жилийг харьцуулбал:

Өвөр Монголд анхны хутагт хэмээн алдаршсан Нэйж тойн бол 1557-1653 оны хооронд амьдарч байсан хүн. Халхын анхдугаар богд Жавзандамба хутагт 1635-1723 оны хооронд амьдарч байсан ба төвдөч эрдэмтэн Л.Хүрэлбаатар, Г.Жамсанжав нарын бичсэн “Монголын найман Богд” номонд хоёрдугаар Богдыг 1724 онд мэндэлсэн, 1728 онд Их Хүрээнд Богдын ширээнд залсан, “Найралт Төв хааны үед Далай лам, Банчин эрдэнэ хоёрын соёрхсон ёсоор бяцхан Богдын номын багшаар Дуйнхор хутагт Манзушрийг тохоон томилсон” хэмээн өгүүлжээ.

Ингээд дээрхи хутагтуудын амьдарч байсан он жилүүдийг харьцуулан харъя:

Халхын Донхор Манзушри хутагтын анхдугаар дүр	1476-1556
Нэйж Тойн	1557-1653
Өндөр гэгээн	1635-1723
Хөх нуурын Донхор Манзушри хутагт	1695-1750
Хоёрдугаар Богд	1724-1757

Ямартай ч Бурхан шашин Өвөр Монголд эхэлж дэлгэрсэнээс гадна хутагт хувилгаан тодруулах уламжлал ч Өвөр Монголоос эхтэй байсан хэмээх А.М.Позднеевын дээрхи мэдээг нягтлуулжтай. Харин хутагт хувилгаад, сүм хийд, лам хуврагийн тоо Өвөр Монголд илүү байсан нь XIX зууны сүүл, XX зууны эхэн үеийн тоон мэдээнээс харагддаг.

Тухайлбал, Оросын судлаач, профессор В.П.Васильевын Бээжинд арав гаруй жил сууж байхдаа гаргасан 144 хутагтын жагсаалт¹ байна:

1. Цахарын Егүзэр тойн хутагт Жамъяандоржийн хувилгаан Норовринчин. 16 нас.
2. Цахарын ... цорж Даваа зайсаны хувилгаан Өлзийтогтоол. 10 нас.
3. Цахарын Эрдэнэ мэргэн цоржийн хувилгаан Жамбалцэрэн нойров. Нас барсан.
4. Цахарын Равжамба Лувсандамбийн хувилгаан Нямаа.
5. Халхын Эрдэнэ Ялгуугсан хутагт Лувсанбалданжигмэд. 30 нас.
6. Халхын Егүзэр Ачит эрдэнэ мэргэн хамба лам Лувсанданзаннамжил. 49 нас.
7. Халхын Ачит Егүзэр дархан хутагтын хувилгаан Наваанданзан. 10 дахь дүр. 15 нас.
8. Халхын Эрдэнэбандид хутагт Лувсанцэвээнжавзан. Нас барсан.
9. Халхын Зая Бандид хутагт Лувсанжигмэднамжил. 46 нас.
10. Халхын Нарванчин хутагт Түгжжав. 32 нас.
11. Халхын Эрдэнэ мэргэн ноён хутагт Цэрэнпунцаг. 40 нас.
12. Халхын Номунхан Бадамдорж. 20 нас.

¹ А.М.Позднеев. Очерки быта монастырей и Буддийского духовенства в Монголии. Улан-Удэ. 2000. Х.239-345

13. Халхын ... хутагтын хувилгаан Ванданчоймбол. 18 нас.
14. Халхын Эрх цоржийн хувилгаан Дамчуй Яринпил. 65 нас.
15. Халхын Тарва бандидын хувилгаан Лувсантүвдэнванчиг. 41 нас.
16. Халхын Шаврун ламын хувилгаан Шагжбал. 50 нас.
17. Халхын Эрдэнэ номч цоржийн хувилгаан Лувсандунгар-Очир. 25 нас.
18. Халхын Зая бандид хутагтын шанзодва засаг лам Дарма. 59 нас.
19. Халхын Эрдэнэ бандидын хувилгаан Лувсанбалданчоймбол. 10 нас.
20. Халхын мэргэн бандидын хувилгаан Цэвэлванчүгдорж. 14 нас.
21. Халхын Жалханц хутагт Лувсанбалжирлхүндэв. Нас барсан.
22. Халхын Ялгуугсан хутагт Лувсансамтүв. 30 нас.
23. Халхын Номун хан Ишданзан. 45 нас.
24. Халхын Ялгуугсан хутагт Лувсансамтүвийн шанзодва засаг лам Лувсандондов. 56 нас.
25. Халхын Жалханц хутагт Лувсанбалжирлхүндэвийн шанзодва Лувсанжамъян. 64 нас.
26. Халхын мэргэн Бандид хутагт Наваанлуvsанжамъян. 11 нас.
27. Халхын Да лам Цэрэндорж. 47 нас.
28. Халхын Да лам Наваанжалцан. Нас барсан.
29. Өргөөгийн Ачит номун хан, Донхор хутагт Лувсанжигмэдцүлтэм. 14 дэх дүр. 23 нас.
30. Өргөөгийн Ялгуугсан хутагт хамба номун хан Жамбалдоржийн хувилгаан Ринчинжав. 8 дахь дүр. 56 нас.
31. Өргөөгийн Эрдэнэ мэргэн бандид Номун хан Сандуйдорж. Нас барсан.
32. Өргөөгийн Мэргэн хамба номун хан Жанцавдоржийн хувилгаан Лувсанчүлтэмжигмэд. 11 дэх дүр. 31 нас.
33. Өргөөгийн Эрдэнэ мэргэн бандид Номун хан Лувсанпэрэнлэйдандарын хувилгаан Дорж. 9 дэх дүр. 27 нас.
34. Өргөөгийн лам Бамбарын хувилгаан Лувсандондов. 5 дахь дүр. 32 нас.
35. Өргөөгийн лам Лувсангэлэгийн хувилгаан Жигмэддорж. 60 нас.
36. Алашагийн Дүвчин хутагт Ишданзан. Өвчтэй.
37. Алашагийн Дагва хутагт Ишцүлтэмдарамжамц. Бээжинд очсон. 26 нас.
38. Сөнөдийн Ганжурва эрдэнэ хамба лам Номун сангийн хувилгаан Садатбадар. 12 нас.
39. Сөнөдийн Эрдэнэ гүүшри мэргэн хамба Наваанжамцын хувилгаан Дондов. 31 нас.
40. Үзэмчиний Мэргэн гүүшри Лувсаншаравнямын хувилгаан Санзайдорж. 21 насандаа нас барсан.
41. Үзэмчиний Да лам, Гүүшри цорж Наваандамбадоржийн хувилгаан Ишдампил. 28 насандаа нас барсан.
42. Үзэмчиний Да лам Эрдэнэ бандид мэргэн хамба Наваандамбапэрэнлэйравжаагийн хувилгаан Үржинжав. Түвд рүү яваад эргэж ирээгүй. 26 нас.
43. Үзэмчиний лам Моломравжамба Галсан түвдэнгийн хувилгаан Дамиран. 18 нас.
44. Авгын Баян шавран Наваанданзанжамцын хувилгаан Рэнчиндаш. 14 настайдаа Түвд яваад эргэж ирээгүй.
45. Авгын гүүшир Лувсангалсангийн хувилгаан Наваантүвдэн. 21 нас.
46. Авгын Наваанлуvsанпэрэнлэйн хувилгаан Намхайноров. 27 нас.
47. Авгын Да лам Лувсандамбаравжаа. 40 нас.
48. Авгын Да лам Наваан-Одсэр. 60 нас.
49. Авгын Чанлун бандид лам Наваанданзанжамц.

50. Авга нарын Эрдэнэ мэргэн хувилгаан Лувсан 12 нас.
51. Авга нарын лам Лувсанданзанжамцын хувилгаан Марайсан. 14 нас.
52. Авга нарын Да лам Ишжамбалсанбу. 75 нас.
53. Авга нарын Да лам Ишжамцан. 75 нас.
54. Хүчит билэгт номун ханы хувилгаан Лувсан. 31 нас.
55. Зуутын Лам Эрдэнэ мэргэн хамбын хувилгаан Навааннирагданзанжамц. 26 нас.
56. Хөх хотын Ширээт хутагт.
57. Хөх хотын хувилгаан Санзайням. Хараахан дахин төрөөгүй.
58. Хөх хотын Нэйж тойн хутагт. 27 насандаа Түвд яваад эргэж ирээгүй.
59. Хөх хотын Засаг лам Галсанишдонров.
60. Хөх хотын Да лам Янчирчын хувилгаан Маха-бирдашири.
61. Хөх хотын Зая бандид хутагтын хувилгаан.
62. Хөх хотын Чойгунав даяанч хутагтын хувилгаан. Насанд хүрээгүй.
63. Хөх хотын Омбожамцын хувилгаан. Хараахан дахин төрөөгүй.
64. Хөх хотын Засаг лам Донровбалдан. Нас барсан.
65. Хөх хотын Засаг да лам Цагаан даяанч хутагт.
66. Хөх хотын Ранжамба дархан цорж хутагт.
67. Хөх хотын Нэннэн хутагтын хувилгаан.
68. Хөх хотын Эрдэнэ даяанч хутагт. Нас барсан.
69. Хөх хотын Цахар даяанч хутагтын хувилгаан.
70. Хөх хотын Засаг лам Содномданзан.
71. Хөх хотын Да лам Лувсандамбаран.
72. Хөх хотын Да лам Гунгаадаваа.
73. Хөх хотын Да лам Ишсоном.
74. Хөх хотын Да лам Лувсангэлцэг.
75. Хөх хотын Да лам Рагвабалдан.
76. Хөх хотын Засаг лам Ёндон.
77. Хөх хотын Да лам Шаравдорж.
78. Хөх хотын Засаг лам Дамчуйбалжир.
79. Хөх хотын Да лам Жамцанням.
80. Хөх хотын Да лам Ишдамба.
81. Хөх хотын Да лам Гончигжамц.
82. Хөх хотын Да лам Равжаа.
83. Хөх хотын Да лам Лувсандондог.
84. Хөх хотын Да лам Гунгаадэлэг.
85. Хөх хотын Да лам Сангижав.
86. Хөх хотын Засаг лам Лувсансамдан.
87. Хөх хотын Да лам Лувсанбалдан.
88. Хөх хотын Да лам Ринчинжамц.
89. Хөх хотын Да лам Жигмэдсамдан.
90. Хөх хотын Да лам Намхайбалдан.
91. Хөх хотын Да лам Өлзий.
92. Жирэмийн ноён хутагт Ишжалцан. 1820 онд насандаа нас барсан.
93. Жирэмийн Багш лам Мижиддорж. 38 нас.

94. Жирэмийн Засаг да лам Наваанрагва. 67 нас.
95. Жирэмийн Да лам Гампил. 65 нас.
96. Жирэмийн Да лам Санзай.
97. Жирэмийн Да лам Дамбажалцан. 42 нас.
98. Жирэмийн Да лам Чойжамц. 70 нас.
99. Горлосын Шаврин хувилгаан Манижав. 47 нас.
100. Горлосын Да лам Аминдаваа. 41 нас.
101. Горлосын Да лам тойн Өлзий дамрага баавай 60 нас.
102. Горлосын Да лам тойн Санжаажав. 61 нас.
103. Горлосын Да лам Иш рагба. 40 нас.
104. Горлосын Да лам Лувсандамцаг. 80 нас.
105. Горлосын Да лам Санрэндорж. 85 нас.
106. Горлосын Да лам Одсэр. 95 нас
107. Горлосын Да лам Лоцой. 88 нас.
108. Горлосын Да лам Чойрог. 80 нас.
109. Горлосын Да лам Батзаяа. 88 нас.
110. Горлосын Да лам Чойрог. 74 нас.
111. Горлосын Да лам Дэлэг. 74 нас.
112. Горлосын Да лам Лувсанмолон. 57 нас.
113. Горлосын Да лам Яшцугдан. 52 нас.
114. Горлосын Да лам Бунирэнцэн. 46 нас.
115. Горлосын Да лам Чой-Одсэр. 25 нас.
116. Горлосын Да лам Наваан-Ёндон. 40 нас.
117. Горлосын Да лам Дансайням. 48 нас.
118. Горлосын Да лам Сулжим. 61 нас
119. Горлосын Да лам Чагдар –Үржин. 50 нас.
120. Горлосын Да лам Ламгу. 64 нас
121. Горлосын Да лам Гомборинчин. 48 нас.
122. Горлосын Да лам Лувсанраш. 50 нас.
123. Горлосын Да лам Дүлзэнбалдансамба. 42 нас.
124. Горлосын Да лам Пирлай. 37 нас.
125. Горлосын Да лам Наваангалсан. 35 нас.
126. Горлосын Да лам Өлзийбадар. 31 нас.
127. Горлосын Да лам Галсаншарав. 63 нас.
128. Горлосын Да лам Наваанданзан. 62 нас. Өвчтэй.
129. Горлосын Да лам Ашук.
130. Жалайдын Да лам Лэгчид. 65 нас.
131. Жалайдын Да лам Баньжав. 72 нас.
132. Жалайдын Да лам Товууч. 59 нас.
133. Жалайдын Да лам Банди. 62 нас.
134. Жалайдын Да лам Сампил. 82 нас.
135. Жалайдын Да лам Жав. 43 нас.
136. Жалайдын Да лам Чойринчин. 70 нас.
137. Жалайдын Да лам Санзайрэнцэн. 65 нас.

138. Жалайдын Да лам Чуань. 62 нас.
139. Жалайдын Да лам Хуваргун. 41 нас.
140. Жалайдын Да лам Энхээ. Нас барсан.
141. Дүрвэд Далай лам Баяндүүрэн. 46 нас.
142. Дүрвэд Далай лам Рааш. 61 нас.
143. Дүрвэд Далай лам Номундэлгэр. 46 нас.
144. Дүрвэд Далай лам Баянхишиг. 72 нас.

Мөн тэр үеийн Ар Монгол дахь шашны асуудал эрхэлсэн Шанзодвын яамнаас гаргасан жагсаалтаас халхын хутагтуудыг Оросын судлаач А.М.Позднеев номондоо дурджээ:

1. Шашныг мандуулагч, амьтныг жаргуулагч Жавзандамба хутагтын хувилгаан.
2. Ачит Номун хан Дүйнхэр хутагтын хувилгаан
3. Ялгуутсан хутагт, Хамба номун хан Жамбалдоржийн хувилгаан.
4. Эрдэнэ мэргэн хутагт Лувсангэлэгийн хувилгаан.
5. Эрдэнэ мэргэн Бандид номун хан Цэвээндоржийн хувилгаан.
6. Мэргэн хамба, номун хан Жанцавдоржийн хувилгаан.
7. Эрдэнэ мэргэн бандид, цорж хамба, номун хан Лувсанпэрэнлэйдандарын хувилгаан.
8. Бамбарын хувилгаан.
9. Шажныг тодруулагч Эрдэнэ Зая Бандид хутагтын хувилгаан. (Энгийн хэллэгт Зая бандид буюу Зая гэгээн гэдэг. Түүний хүрээ хийд, өргөө гэр нь Сайн ноён хан аймгийн нутагт байдаг ба өмнөх жагсаалтын 61-д буй Хөх хотын ижил нэрт хувилгаантай андуурч болохгүй)
10. Эрдэнэ бандид хутагт, хамба номун хан. (Энгийн хэллэгт Номун хан Лам гэдэг. Түүний өргөө гэр нь Сэцэн хан аймагт байдаг.)
11. Чин сүжигт номун хан, Эрдэнэ хамба хутагт. (Энгийн хэллэгт Чин сүжигт лам гэдэг)
12. Эрдэнэ мэргэн бандид Цэцэн номын хан. (Энгийн хэллэгт Эрдэнэ хамба хутагт гэдэг)
13. Номч мэргэн хамба, Эрдэнэ бандид Жалханц хутагт.
14. Соёлыг бадруулагч сүмийн хамба Нарванчин хутагт. (Энгийн хэллэгт Нарванчин гэгээн гэдэг)
15. Эрдэнэ Ялгуутсан Хутагтын хувилгаан. (Энгийн хэллэгт Лха Бэйсийн Ялгуутсан гэдэг)
16. Егүзэр ачит Эрдэнэ мэргэн сэцэн хамбын хувилгаан.
17. Зарлигаар Их ухаант цол шагнагдсан Цорж хутагт Эрдэнэ хамба, эрх сэцэн тойн. (Энгийн хэллэгт Мэргэн вангийн тойн хамба гэдэг. Хүрээ хийд, өргөө гэр нь Түшээт хан аймгийн Мэргэн вангийн хошуунд байдаг)
18. Ялгуутсан хамба, Сайн ерөөлт ширээт номч, номун хан. (Энгийн хэллэгт Хавчиг хувилгаан гэдэг)
19. Хувилгаан цорж, номч Эрдэнэ бишрэлт (Энгийн хэллэгт Ноён лам гэх бөгөөд Баруун хүрээнээс холгүй Пунцагдаржаалан хийдэд суудаг)
20. Эрдэнэ ялгуутсан ширээт, билэгт гавж хувилгаан. (Энгийн хэллэгт Шавийн Галсан ширээт гэдэг)
21. Шажныг тодруулагч, сайн ерөөлт, номч мэргэн хамба, сэцэн ширээт Дарва бандид хутагтын хувилгаан.

22. Хувилгаан Галсан ширээт.(Энгийн хэллэгт Хатгиний Галсан ширээт гэдэг)
23. Шажныг тодруулагч, Эрдэнэ мэргэн ноён хутагт.(Энгийн хэллэгт Сайн ноёны дүү хувилгаан гэдэг. Өргөө гэр нь Сайн ноён хан аймагт байдаг)
24. Тойн хамба хувилгаан, Үлэмж сайн номч мэргэн.
25. Тойн хамба хувилгаан, Үлэмж сайн номч мэргэн. (Энэ хоёрыг ялгахын тулд эхнийхийг нь энгийн хэллэгт пууппаг Лха бээсийн тойн гэсэн байх ба харин албан бүртгэлд зөвхөн хошуугаар нь ялгажээ)
26. Цорж хувилгаан Дамбажунай.
27. Шажныг тодруулагч, Эрдэнэ мэргэн ноён хутагт.(Өмнөх ижил нэр цолтой Сайн ноёны дүүгээс ялгахын тулд Говийн ноён хутагт гэдэг.)
28. Эрдэнэ мэргэн ширээт (Энгийн хэллэгт Лха бээсийн ширээт гэдэг)
29. Хувилгаан дархан цорж Лувсандамбажалцангийн хувилгаан.
30. Ялгуугсан хутагт ноён номун хан.
31. Аймаг савыг баригч, ачит номун хан, эрдэнэ Манзушир Донхор хутагт. (Халхад сүм хийдтэй ч одоо Долнуурын орчимд Цахарын нутагт байнга суудаг. Энэ хутагтыг Өргөөгөөс холгүй амьдардаг Жавзандамба хутагтын мэдлийн Донхор Манзушир хутагтаас ялган үзэх хэрэгтэй)
32. Мэргэн хамба номун ханы хувилгаан.
- 33.Эрдэнэ мэргэн бандид номун ханы хувилгаан.
34. Мэргэн хутагт
35. Эрдэнэ хувилгаан.
36. Эрдэнэ цогт хутагт. (Энгийн хэллэгт Арын хувилгаан гэх ба Засагт хан аймгийн нутагт амьдардаг)
37. Хувилгаан гүүш, Дондов номч билэгт
- 38.Тойн цоржийн хувилгаан.
39. Номч номун хан.
40. Гунгаабандидын хувилгаан.
41. Засаг да лам, Оромбо хутагтын хувилгаан.
42. Эрдэнэ бандид ламын хутагт. (Энгийн хэллэгээр Ламын гэгээн гэх ба Сайн ноён хан аймагт суудаг)
43. Мэргэн хамба Хүүхэн хутагтын хувилгаан. (Энгийн хэллэгээр Хүүхэн хутагт гэх ба орон хүрээ нь Сэцэн хан аймагт байдаг)
44. Ялгуугсан хамба Ганжурва гэгээн. (Сэцэн хан аймагт суудаг)

А.М.Позднеев дээрхи 44 хутагтын нэрсийг жагсаасан боловч Халхад тухайн цаг үед нийт 118 хутагт хувилгаан байна гэсэн тоон мэдээллийг өгсөн нь өнөөгийн Орос, Монголын олон судлаачдын эш татаж буй тоо юм.

Одоо хутагт хувилгаадын тоо ба сүм хийдийн тоог харьцуулж үзье.

1937 оны байдлаар Монголын сүм хийдийн тоог гаргасан судлаач Д.Майдарын “Монголын архитектур ба Хот байгуулалт” номонд 737 сүм хийдийн жагсаалт гаргасан байна. Үүнийг 1970-80-аад онд түүхч эрдэмтэн С.Пүрэвжав “Шарын шашны хураангуй түүх” (УБ 1978) номондоо болон “Монголын сүм хийдийн түүхэн товчоон” (УБ 2009)

төслийнхөн судалгаандаа ашиглажээ. Энэ мэдээлэл нь Ли Пан юан¹ дансанд өгүүлсэн Өвөр монголд 1200 гаруй сүм, Ар халхад 700 гаруй сүм хийд байсан гэсэн мэдээлэлтэй үндсэндээ нийцэж байна.

XX зууны эхэн үеийн Өвөр Монгол дахь бурханы шашны талаархи тоон мэдээллийг “Ламын сүм ба лам нарын тоо”² хэмээх бүртгэлээс харж болох юм. Уг бүртгэлд Нуун арван хошууны сүм хийд, лам нарын тоог дараахь байдлаар мэдээлснийг жишээ болгон харъя.

Нуун арван хушуу	Сүм	Лам нарын тоо
Хорчин баруун гарын дундад хошуу	15	764
Хорчин баруун гарын өмнөд хошуу	7	837
Хорчин баруун гарын хойд хошуу	5	131
Хорчин зүүн гарын дундад хошуу	74	3544
Хорчин зүүн гарын өмнөд хошуу	20	771
Хорчин зүүн гарын хойд хошуу	43	1728
Залайд хошуу	15	735
Дөрвөд хошуу	10	209
Горлосын өмнөд хошуу	4	482
Горлосын хойд хошуу	16	285

Бас нэгэн сонирхолтой тоо мэдээ бол сүм хийдийн жас, харьяа мал аж ахуйн талаарх тоо мэдээ юм. Ар Монгол дахь жасын талаар академич Ш.Нацагдорж “Сүм хийд, шавь ард” номондоо тодорхой гаргасан буй. Харин Өвөр Монголын сүм хийдийн мал ахуйн тухайд, Чин улсын сүүлчийн үеэс хойших Долон нуурын Хөх сүм ба Шар сүмийн эд хөрөнгө, хүн амд нарийн тооллого хийж, 14 хутагт хувилгаадын сан ба 10 албаны сангийн харьяат хүн ам, мал сүрэг, түрээсийн гэр байшин зэргийн тоо хэмжээг нарийн жагсаажээ. Үүнд:

Сангийн нэр	Шавь өрхийн тоо	Хүн ам			адуу	үхэр	хонь	Түрээсийн гэр байшин
		эр	эм	бүгд				
Жанжаа	83	10	43	53	00	44	33	7
Ширээт	63	5	6	01	00	10	127	5
Ажа	44	9	05	84	0	31	031	4
Ганжуур	50	2	01	93	0	15	05	5
Далай хамба	33	8	8	16	13	40	650	
Мэргэн номын хан	58	05	22	27	50	099	093	5
Билигт номын хан	12	4	1	5		9	25	
Жирэн	5		1	0		1		2

¹ 理藩院 (li pan yuan)

² 任月海 • 多伦县文史资料 (二) (M) • 呼和浩特: 内蒙古大学出版社, 2006, . 52..

Ноён цорж	20	8	2	0		3	7	3
Арх	25	5	0	5		37	202	Тодорх ойгүй
Минжүүр	42	4	7	1	0	80	50	
Их жас	14	9	0	9	5	5	4	2 0
Сандуй	1							3
Чойр								
Нөннай								
Түмэт	4			1		4		1

Одоо тоон үзүүлэлтийн ард ямар чанарын асуудал нуугдаж байсныг тодруулъя.

Ли Пан юан¹ данс эмхтгэл буюу “Гадаад Монголын төрийг засах явдлын яамны хууль бичиг”-г мэдээлсэн Өвөр Монголд 1200 гаруй сүм, 157 хутагт хувилгаад, Д.Майдарын “Монголын архитектур ба Хот байгуулалт” номонд мэдээлсэн Ар Монголын 737 сүм хийд, А.М.Позднеевын мэдээлснээр Ар Монголд 118 хутагт хувилгаад байжээ гэж үзвэл дараахь тоон харьцааг гаргаж болох юм:

Өвөр Монголд: $1200 : 157 = 7.64$

Ар Монголд: $737 : 118 = 6.2$

Өөрөөр хэлбэл, Өвөр Монголд нэг хутагтад ойролцоогоор 7-8 сүм оногдож байхад Ар Монголд нэг хутагтад дунджаар 6 сүм ноогдож байжээ гэж үзмээр тоон харьцаа гарч байна. Тоон мэдээлэл маань өөрөө Өвөр Монголд сүм хийд ч, хутагт хувилгаад ч олон байсныг харуулж байгаа бол дээрхи тоон харьцаанаас Өвөр Монголд хутагтаасаа илүү олон сүм, Ар Монголд сүм хийдээсээ илүү хутагт хувилгаад байжээ гэсэн дүгнэлт гаргаж болохоор байна. Гэвч ийм тоон харьцаанд тулгуурлаж шууд дүгнэлт хийх нь учир дутагдалтай юм.

Хутагтууд сүм хийдүүдийг шууд хамаарч мэдэж байсан уу гэвэл тийм биш байна. Хутагтын харьяаны сүм хийд нь бусад сүмээсээ хамааралгүй байсан нь А.М.Позднеевын судалгаанаас харагддаг. Тэрээр Монголын сүм хийдүүдийг үүсэл гарлынх нь хувьд дөрвөн бүлэг болгон ангилсан байдаг:

1. Манжийн эзэн хааны байгуулсан сүм
2. Нутгийн хүмүүсийн байгуулсан хошууны хийдүүд;
3. Хувь хүмүүсийн байгуулсан хийдүүд
4. Гэгээн, хутагт, хувилгааддаа зориулж байгуулсан хийдүүд

Эдгээрийн дотроос ард олны зүгээс хамгийн их өргөл хандив цуглардаг, сүсэгтэн олон хамгийн их тойрон хүрээлдэг, лам хувраг, шавь ардын тоо нь хамгийн их өсдөг, хамгийн хурдацтай өргөжин тэлдэг, хамгийн баян чинээлэг хийд нь хутагтын хийд байсныг үйл ажиллагаагаар нь А.М.Позднеев нотлон гаргажээ. Чухам яагаад монголчууд

¹理藩院 (li pan yuan)

хутагт хувилгаадаа илүү дэмжиж тэтгэж, өргөн хүндэлж ирсэн нийгмийн сэтгэлзүйн олцлогийг гаргахын тулд “хутагт” хэмээх ойлголтыг түүхэн сурвалжуудад хэрхэн тэмдэглэснийг авч үзвэл, XIII зуунд Хутагтан гэсэн ойлголт нь “ариун нандин”, “эрхэм дээд” гэсэн утгыг илэрхийлж байсан ба эрхэм дээд манлайлагч, “лидер” хүмүүсийг Эрхэм шүтээн, Сахиус гэсэн утгаар өргөмжилж байжээ. Өөрөөр хэлбэл, монголчуудын шүтэн дээдлэх эрхэм зүйл нь овог угсаа, үндэс язгуураа зөв замаар удирдан манлайлагч, хаад язгууртнууд байсан гэж хэлж болно.

Хубилай сэцэн хааны үеэс эхлэн монголчуудын дунд төвдийн Бурханы шашны ёс ихэд дэлгэрснээр *Монголын хутагтан хаад* бол зөвхөн Монгол газраа төрсөн тэргүүлэгчид, манлайлагчид төдийгүй хамаг төрөлхтөний түгээмэл эрмэлзлийг хангах бүх нийтийн нэгдмэл зорилгыг илэрхийлэгчид мөн гэдгийг илэрхийлэн, бурханы шашны их хөлгөний ёс дэлгэрсэн Энэтхэг, Төвдийн хаадтай нэгэн хувилгаан төрлийн холбоотой, хүрдэн эргүүлэгч чакраварти хаад хэмээн тайлбарлах болжээ. Үүгээр “*Монголын тэнгэр язгуурт хутагтан хаад*”-ын үзэл санаа, үйл хэрэг нэг талаас харахад, Энэтхэг, Төвдөөр дамжуулан Дорнын соёл иргэншлийн хүрээнд даяршлагдаж эхэлсэн боловч, нөгөө талаар, тэрхүү даяаршлын өргөн талбарт Монголын өөрийн гэсэн соёл, ертөнцийг үзэх үзлийг улам тодоор илэрхийлэгчид болсон юм.

Өвөр Монголд гарсан толь бичгүүдэд хутагт гэдэг үгийн язгуурыг “хутаг” гэсэн түрэг үг, лам хүмүүний хамгийн дээд цол, Богдын дараа орох цол, төвдөөр пагва, санскритаар арьяа хэмээн тайлбарлажээ.

“Тадаад Монголын төрийг засах явдлын яамны хууль бичиг”¹-т тэмдэглэснээр аливаа хутагтыг арван найман нас хүрсний дараа жинхэлнэ² гэжээ. Мөн жинхэлсэн хутагтад тамга барих эрхийг олгодог байжээ. Хутагтын тамга гэдэг нь Чингийн үеийн алтаар өнгөлсөн мөнгөн тамгыг хэлэх ба өргөн нь 6.5см, тэг дөрвөлжин хэлбэртэй, жаазны хүрээний урт 8см байжээ. Тухайн үеийн тамгатай хутагт нар төр шашин хоёр зүйлийн эрхтэй байв. Мөн Чин улсаас лам нарын тоог хязгаарлах зорилгоор олгодог байсандүдьяа бичиг³ нь Чин улсаас Монголд хэрэгжүүлж байсан шашин суртахууны бодлогыг ойлгож мэдэхэд чухал хэрэглэгдэхүүн болно.

“XV-XVI зуун бол монголчуудын задрал бутралын үе гэдгээрээ Монголын түүхэнд тэмдэглэгдсэн үе. Энэ үеийг даван туулахын тулд нэгдсэн төр улс байгуулж чадах тийм эзэн Богдыг тодруулах нь монголчуудын хувьд амин чухал зорилт болж байв. Нөгөө талаар улс төрийн хатуу үйлийг шашин-номын ёсоор зөөлрүүлэн төв голч байр суурийг барих хос ёсны бодлогыг хэрэгжүүлж амжилтанд хүрсэн Хубилай сэцэн хааны үйл хэргийг үргэлжлүүлэх хүсэл эрмэлзэл бутралын үеийн Монголын бага хаадын хүсэл мөрөөдөл болсон юм. Үүний хэрэгжилт болж Халхын гурван хан урьдчилан зөвшилцсөний дагуу 1639 онд Занабазарыг Монголын шашны тэргүүн “Богд Жавзандамба хутагт” хэмээн өргөмжилсөн нь угтаа шашин-номын ёсоор монголчуудыг эвлэрүүлэн нэгтгэж, Монголын нэгдсэн төрийг байгуулах үзэл санаан дор зохион байгуулагдсан үйл

¹ Өвөр Монголын Соёлын хэвлэлийн хороо.1989 он. 1356-р зүйл

² Монгол судлалын нэвтэрхий доли -шашин суртахуун. Өвөр монголын ардын хэвлэлийн хороо, 2007 он 7 сар. хуудас 304.

³ Лам нарын биеийн гэрч тэмдэг, харгалзлал хүртэх тэмдэг бичиг, мөн лам нарын тоог хязгаарлах арга бодлого болно.

хэрэг мөн. Занабазарыг өргөмжилсөн “Богд”, “хутагт” хэмээх өргөмжлөлүүд нь тухайн үеийн монголчуудын хувьд “тэнгэр заяат Чингис хаан” гэсэн утгыг далдуур илэрхийлж, жирийн хүнээс ялгаатай, авьяас билиг төгөлдөр, онцгой дээд удирдагч төрсөн хэмээх итгэлийг өөрийн эрхгүй төрүүлж байв.

Монголчууд аль болох Манжийн засаг захиргааны харъяаллаас ангид байхыг эрмэлзэж, Богд Жавзандамба хутагтыг Монголын шашны тэргүүн гэсэн утгаар ихэд дээдэлж, түүнийг зөвхөн шүтэж биширч байсан төдийгүй, биеийн хүчний хөдөлмөр зүтгэл болон санхүүгийн хувьд бүх талаар дэмжин тойрон хүрээлж байсан нь XX зууны эхэнд Богд хаант Монгол улс байгуулагдах нийгмийн сэтгэлзүй болон эдийн засгийн нөхцлийг бүрдүүлсэн гэж хэлж болохоор байна”¹.

Одоо дээрхи тоон ба чанарын үзүүлэлтүүд Монголын нийгмийн амьдралд ямар нөлөө үзүүлсэн талаар ярилцъя.

Манжийн зүгээс явуулж байсан шашны бодлогод монголчууд өөр өнцгөөс хандаж байсан юм.

Монгол дахь бурхан шашны дэлгэрэлт нь хутагт хувилгаадыг шүтэх үзэлтэй нэгдэж, Монголд олон түмнийг бурханы шашны үйл хэрэг, оюун санаагаар удирдан манлайлагчид олшрохын хэрээр сүсэгтэн олны чин сэтгэлийн дэмжлэг хүрээллийн тусламжтайгаар өргөжин тэлж, хутагт нарын томоохон хүрээ хийд бий болсон нь сүүлдээ монголчуудын оюуны соёлын төв, хот суурин болж өргөжжээ. Өөрөөр хэлбэл, сүм хийдүүд нь зөвхөн хурал номын газар төдийгүй, шинжлэх ухааны олон салбаруудыг судалдаг дацан сургуулиуд, одоогийхоор их сургуулиуд болж хөгжсөн юм.

Нөгөө талаар, Монголын сүм хийдүүд нь шашин шүтлэг, ном эрдэм, урлаг утга зохиол зэрэг оюуны соёлыг хөгжүүлэх гол төвүүд байснаас гадна монголчуудын амь амьжиргааг хангаж, эдийн засгийг хөгжүүлэх уул уурхай нь болж байв.

Монголын Богдууд болон хутагтууд бурханы шашин номыг Монгол газраа өргөн дэлгэрүүлж, шашин ном, оюун санаагаар нь монголчуудыг нэгтгэх, улмаар Монголын далд эдийн засаг, цэрэг хүчийг ч бэхжүүлж, тусгаар тогтнолоо олох зорилго тавьж байсан нь XIX зуунд Монголын бараг бүх сүм хийдээр зочилсон Оросын нэрт монгол судлаач А.М.Позднеевын тэмдэглэлээс харж болно.

Монголчууд Манжийн ноёрхолын үед Манжийн хууль цаазын зэрэгцээгээр “Халх журам”-ыг хууль цаазын эрхтэйгээр мөрдөж, хүрээ хийдэд онцгой эрх олгож, ард олон Манжийн засаг захиргааны албанд зүтгэхээс илүү Богд Жавзундамба тэргүүтэй Монголын хутагтуудын биеийн ба эд хөрөнгөний албанд зүтгэхийг илүүд үзэх болсон нь угтаа Монгол хаандаа зүтгэж байгаатай ижил санааг агуулж байлаа. Монголчууд бурхан шашнаараа нэгдэн, шашны тэргүүн Богдоо тойрон хүрээлж, түүхэн нөхцөл бүрэлдмэгц Монголын төрөө сэргээж, нийгэм-соёлоо дахин мандуулах сууриа бэлтгэж, Монголын хутагт лам хуврагууд зөвхөн шашин номын төдийгүй үндэсний эв нэгдэл, тусгаар тогтнолынхоо төлөө нийгэм улс төрийн амьдралд идэвхийлэн оролцож байсан байна.

¹ “Богд хаан-150 түүх, соёл, өв” олон улсын эрдэм шинжилгээний хурлын хөтөлбөр, илтгэлийн хураангуй. УБ 2019.

XX зууны эхэн гэхэд зөвхөн Богд тэргүүтэй хутагтуудын шавь ард төдийгүй Монголын дийлэнх эрчүүд шавьлан сууж байсан ар Монголын 700 гаруй хийд орон бүгд Богдын удирдлаган дор нийгмийн үйл хэрэгт оролцоход бэлэн болсон байв. Энэ нь Монголд Ардын засаг байгуулагдсанаас хойш Богд тэргүүтэй Монголын хутагт хувилгаад, шавь ард, лам хуврагуудад тохиолдсон их хэлмэгдэл, тэдний мал сүрэг, өв хөрөнгө, соёлын өвийг устгасны шалтгаан болсон юм. Учир нь энэ бүхэн ард олны бишрэл сэтгэлд тулгуурлан сүндэрлэсэн Богд хаант засгийн хүч чадлыг илтгэж байв.

Эцэст нь ардчилал, зах зээлийн нийгэмд шилжсэн энэ цаг үед эргэн тодроод байгаа хутагт хувилгаадын талаар товч дурдъя.

Одоогоор ар Монголд 20, Өвөр Монголд 2 хутагт шинээр тодроод байна. Монгол сүсэгтнүүдийн уламжлалт түүхэн хүсэл сэтгэл бол өнөө цаг үед Монголын гэсэн үндэсний онцлогтой оюуны соёлыг манлайлах оюуны манлайлагчид гэж ард түмэн тэднийг харж найдаж байгаа гэдгийг тэмдэглэн хэлье.

Монгол Улсад шигнээр тодорсон хувилгаад:

1. Дилова хутагт Данзанламид
2. Заяын гэгээн Лувсанданзанпүлжинжигмэд
3. Гачэн хувилгаан Ринчинсамбуу
4. Жалханз хутагт Данзанчойживанчүг
5. Гүшри хувилгаан Данзанчойжиням
6. Жонан Ханчэн хувилгаан Лувсанчойдог
7. Ламын гэгээн Данзанжамбалчойжишинэн
8. Манзушир хутагт Данзанжамъяндорж
9. Срайдорж Номун Хан Лувсандамбийжалцан
10. Банбар Эрдэнэ хутагт Дүр Данзанпэрэнлэйгүнчав
11. Баригри хувилгаан Дэнзэнжамъянлодойнамжил
12. Ноён хутагт Данзанлуvsантүдэв
13. Дарба Бандида хувилгаан Данзанчойжилодой
14. Наро Банчэн гэгээн Данзанлхүндүв
15. Жамьянгараг гэгээн Данзанжигварал
16. Егүзэр хутагт Данзанлуvsанванжил
17. Сэнгээ ринбүүчи Дэнзэнчойдэн
18. Эрдэнэ бишрэлт мэргэн бандида Данзанжамъянлодой
19. Ялгуусан хутагт Данзанванчүг
20. Хараагийн Дарь эхийн хувилгаан Дэнзэндэнжон

Өнөө үед Монгол улсад хутагтуудаа ихээр эргэн тодруулж байгаагийн цаана Буддын сургаалын ёсзүйн үүрэг, хүмүүжлийн ач холбогдлыг илүү анхаарч, энэ зорилгоор Буддизмыг ихэд сурталчилж байна. Буддын шашны үзэл санаагаар өсвөр үеэ хүмүүжүүлэн төлөвшүүлэх шаардлага улам хүчтэй тавигдаж байна. Гэхдээ өнөөгийн залуучууд шашны хэвшмэл номчирхол, хоосон цэцэрхэлд татагдахгүй нь ойлгомжтой. Гагцхүү бурханы сургаалыг хүүхэд залуучуудын сонирхол таашаалд нийцэхүйц тийм эдүгээчлэгдсэн, орчин үежсэн хэлбэр агуулгаар номлох аваас сая ач холбогдол, утга учир нь амьдралд хэрэгжих боломжтой болно.

Монголын Бурханы шашинтнууд залуу хойч үеийнхэндээ зөв шударга, хүнлэг энэрэнгүй, өрөвч нигүүлсэнгүй хүмүүжил төлөвшил олгож, түүхэн уламжлалаа даган үндэстний соёлын үнэт зүйлс, дархлаагаахадгалж үлдээх, эх оронч үзлийг түгээн

дэлгэрүүлэх, бусад шашин шүтэгчид, эс шүтэгчид болон бурхан шашины доторхи олон салбар чиглэлүүдийг тэгш хүндэтгэн үзэж, хүний эрх, эрх чөлөөг дээдлэн, Монгол улсын ирээдүйн хөгжил дэвшлийн төлөө хамтран тэмцэхэд өндөр байр суурьтай оролцоно гэдэгт найдаж байна.

НОМ ЗҮЙ

1. “Богд хаан-150 түүх, соёл, өв” олон улсын эрдэм шинжилгээний хурлын хөтөлбөр, илтгэлийн хураангуй. УБ 2019
2. Монгол судлалын нэвтэрхий доли -шашин суртахуун. Өвөр монголын ардын хэвлэлийн хороо, 2007 он 7 сар. хуудас 304.
3. 任月海·多伦县文史资料（二）（М）·呼和浩特：内蒙古大学出版社，2006,. 52..
4. А.М.Позднеев. Очерки быта монастырей и Буддийского духовенства в Монголии. Улан-Удэ. 2000. X.239-345

ABSTRACT

Purpose of our research is to reveal how were studied Mongolian “khutugtus” (bodhisattva incarnations) in Russia and China, are there any differences between numbers revealed by them, how to connect numbers studies of khutugtus to psychology study of Mongolian people, in this way to establish relationship between quantitative and quality studies on Mongolian khutugtus.

In this presentation we are going to talk about next two issues:

First, compare Russian and China source information about Mongolian khutugtus,
Secondly, consider socio-psychological basis in Mongolia to clarify the Khutugtus.

Recent Russian and Mongolian researchers have been quoted from the Russian researcher A.M.Pozdneev who studied Mongolian Buddhism of XIX century. So we tried to compare this study with some China information about Manchu period. Also we are going to discuss the socio-psychological bases of the Mongolian people for clarification khunugtus, how this situation works today when many khutugtus have been reborn.

Finally, the goal was to clarify the relationship between quantitative and qualitative characteristics of khutugtus.